



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.05 № 01/728  
танай -ны № -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЧАНДМАНЬ-  
ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
БҮҮВЭЙГИЙН ОТГОНТОГОХ  
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Бүүвэйгийн Отгонтогтохын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгур болгон авч үзсэн.

## Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Бүүвэйгийн Отгонтогтохын Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох бусад хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.


Бие даан нэр дэвшигч Бүүвэйгийн Отгонтогтохын сонгуулийн мөрийн хөтөлбөр (1 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Бүүвэйгийн Отгонтогтоход

Хувийг: Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Сонгуулийн хороонд

Хавсралт . . . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ИТХ-ЫН СОНГУУЛЬД  
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ БҮҮВЭЙ ОВОГТОЙ ОТГОНТОГОХ  
МИНИЙ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР


НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА

Сум орон нутгийн онцлог, түүх өв соёлыг сэргээх сумын ИТХ-ын үйл ажиллагаанд иргэдийг төлөөлөн эрх ашгийг хамгаалах талаар манлайлан оролцож төлөөлөгчийн үүргээ бүрэн бүелүүлэн ажиллах

ХОЁР. Хөтөлбөрийн үндсэн заалт

1. Боловсролын чанарт онцгой анхаарч удирдлага менежментийг сайжруулах өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ
2. Хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, авьяас чадварыг хөгжүүлэх, хүүхдэд ээлтэй орчин нөхцөл бий болгох санал санаачлалтыг дэмжин энэ чиглэлээр төрөл бүрийн сургалт зохион байгуулах
3. Соёл урлаг, соён гэрээрүүлэх чиглэлийн олон талт арга хэмжээ, өв соёлоо өвлүүлэн үлдээх уран зураг зурахыг зааж сургахад хамтран ажиллаж үйлчилгээний нэр төрөл чанарыг нэмэгдүүлнэ.
4. Нутгийн зохиолчдын дууны наадам, гар урчуудын бүтээлээр жил бүр үзэсгэлэн зохион байгуулах
5. Орон нутаг судлах танхимын үзмэрийг нэмэгдүүлэх гадаад дотоодын жуулчид, орон нутгийн иргэдэд үйлчилдэг болох нөхцөл бий болгоно.
6. Нутгийн багшлах боловсон хүчнийг сум орон нутагтай хамтран дэмжиж туслаж ажиллана
7. Хүүхдийн сурч боловсрох таатай орчинг бүрдүүлэх, төрөл бүрийн сургалтыг зохион байгуулах
8. Эх хүүхдийн эрүүл мэндэд анхаарч, зорилтот бүлгийн хүүхдүүдийг сувилалд сувилуулах болон зуны гэр цэцэрлэгт малчдын хүүхдүүдийг бүрэн хамруулахад анхаарч ажиллана.
9. Малын гаралтай түүхий эдийг боловсруулах нутгийн брэнд бүтээгдэхүүний чанарыг сайжруулах төрлийг олшруулахад анхаарч ажиллах
10. Иргэдийн оролцоотой Байгаль орчныг хамгаалах уламжлалт арга барилаас суралцах, зөв дадал зан үйл бий болгох олон төрлийн ажил зохион байгуулах

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН Б.ОТГОНТОГОХ



0000001